



**ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ХЭЛТЭС**

АВЛИГЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ЖУРАМ

Баримт бичгийн дугаар: АЭҮЖ-03-2023

Баталсан:

Нийгмийн даатгалын хэлтсийн даргын үүргийг түр орлон
гүйцэтгэгч, Чанарын удирдлагын хорооны дарга

Д.НАРМАНДАХ

Хянасан:

Авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх
ажлын хэсгийн дарга

Н.БАТ-ЭРДЭНЭ

Боловсруулсан:

Дотоод хяналт шалгалтын багийн дарга

Г.ГАЛБАДРАХ

Баримт бичгийн мэдээлэл

Баримт бичгийн хариуцагч	Тушаалын дугаар	Баталсан огноо	Мөрдөж эхлэх огноо	Хуудасны тоо
Орхон аймгийн НДХ				

2023 он

АГУУЛГА

1. Зорилго
2. Хамрах хүрээ
3. Хамаарах талууд
4. Баримт бичгийн хариуцагч
5. Нэр томъёо, тодорхойлолт, товчлол
 - 5.1. Нэр томъёо, тодорхойлолт
 - 5.2. Товчилсон үг
6. Нөхцөл байдлыг тодорхойлох
 - 6.1 Ерөнхий зүйл
 - 6.2 Гадаад нөхцөл байдлыг тодорхойлох
 - 6.3 Дотоод нөхцөл байдлыг тодорхойлох
 - 6.4 Авлигын эрсдэлийн шалгуурыг тодорхойлох
7. Эрсдэлийн үнэлгээ
8. Мониторинг ба хяналт
9. Хавсралт баримт

1. Зорилго

Авлигын эсрэг хуулийн хүрээнд авлигын шалтгаан нөхцлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах, арилгахад чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэхийн тулд авлигын эрсдэлээ үнэлж тодорхойлоход оршино.

2.Хамрах хүрээ

Нийгмийн даатгалын байгууллагын авлига ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан нөхцөл түүнийг тодруулах, урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоонд холбогдох чанарын хяналт, стандарт үйл ажиллагааны журам, ажлын заавар, бүртгэлийн маягтуудыг хамруулсан нийгмийн даатгалын бүхий л үйл ажиллагаа хамаарна.

3. Хамрах талууд

- 3.1 Эрсдэлийн үнэлгээний хамрах хүрээ нь үнэлгээ хийж буй байгууллагын цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, чадавх, нөөц боломжоос хамааран харилцан адилгүй байж болно.
- 3.2 Үнэлгээнд байгууллагыг бүхэлд нь эсхүл хэлтэс, алба, нэгжийг хамруулж болно.
- 3.3 Эрсдэлийн үнэлгээг байгууллагын үйл ажиллагааны дараах чиглэлээр тусгайлан зохион байгуулж болно:
 - 3.3.1.1 Чиг үүрэг, бүтэц
 - 3.3.1.2 Төсөв, санхүү
 - 3.3.1.3 Шийдвэр гаргах явц
 - 3.3.1.4 Ил тод байдал
 - 3.3.1.5 Хариуцлага тооцох механизм
 - 3.3.1.6 Мэдээллийн хүртээмж
 - 3.3.1.7 Бүртгэл
 - 3.3.1.8 Хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалт
 - 3.3.1.9 Ёс зүй, шударга байдлын түвшин
 - 3.3.1.10 Өргөдөл, гомдол, мэдээлэл
 - 3.3.1.11 Авлигын эсрэг бодлого
 - 3.3.1.12 Сургалт, давтан сургалт
 - 3.3.1.13 Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл
 - 3.3.1.14 Бусад

4. Баримт бичгийн хариуцагч

Авлигатай тэмцэх менежментийн тогтолцооны Чанарын удирдлагын хороо, Эрх бүхий албан тушаалтан нар нь баримт бичгийн хариуцагч байна.

5.Нэр томьёо ба тодорхойлолт

5.1 Энэ баримт бичигт дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

5.1.1 "авлига" гэж төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг;

5.1.2 "ашиг хонжоо" гэж төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосны төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;

5.1.3 "албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах" гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг;

5.1.4 "давуу байдал" гэж төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;

5.1.5 "олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа" гэж олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд тэднийг татан оролцуулах арга хэмжээний цогцолборыг;

5.1.6 "авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа" гэж авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, тэдгээрийг арилгах, авлигыг таслан зогсооход чиглэгдсэн арга хэмжээний цогцолборыг;

5.2 Товчилсон үг

Товчилсон үг	Тайлбар
ISO	Олон улсын стандартын байгууллага
АТМТ	Авлигатай тэмцэх менежментийн тогтолцоо
ЧУХ	Чанарын удирдлагын хороо
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан
ДХШБ	Дотоодын хяналт шалгалтын баг
АЭМТХАХ	Авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хэсэг
АШБ	Анхан шатны бүртгэл
СҮАЖ	Стандарт үйл ажиллагааны журам
ББНС	Баримт бичгийн нэгдсэн сан
ЧГА	Чанарын гарын авлага

6. Нөхцөл байдлыг тодорхойлох

6.1 Ерөнхий зүйл

Нөхцөл байдлыг тодорхойлсноор хэлтсийн авлигын эрсдэлийг удирдахад харгалзаж үзэх гадаад болон дотоод үзүүлэлтээ тогтоож, цаашдын үйл явц дахь эрсдэлийн шалгуур, хамрах хүрээгээ тодорхойлно.

6.2 Гадаад нөхцөл байдлыг тодорхойлох

Гадаад нөхцөл байдал бол хэлтэс зорилгодоо хүрэхийг эрмэлзэх үеийн гадаад орчин юм.

Авлигын эрсдэлийн шалгуурыг боловсруулахдаа гадаад оролцогч талуудын зорилт, санаа бодлыг харгалзаж байх үүднээс гадаад нөхцөл байдлын ойлголт чухал байдаг. Энэ нь хууль, эрх зүйн зохицуулалтын шаардлагын онцлог заалтууд, оролцогч талуудын ойлголт болон эрсдэлийн менежментийн үйл явцын хамрах хүрээн дэх тухайн эрсдэлийн бусад асуудлыг хамарсан хэлтсийн өргөн хүрээний нөхцөл байдалд үндэслэнэ.

Гадаад нөхцөл байдалд:

- Бүс нутаг ба орон нутгийн соёл, нийгэм, улс төр, эрх зүйн орчин, санхүү, технологи, эдийн засаг, байгаль орчны болон өрсөлдөөний байдал
- Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшин, ажилгүйдэл ядуурал,
- Ажил олгогч болон даатгуулагчдын мэдлэг мэдээлэл, хүний суурь хөгжлийн түвшин, ухамсар
- Хэлтсийн зорилгод нөлөөлөх үндсэн хүчин зүйл, хандлага,
- Харилцан ажиллагаатай гадны оролцогч талуудын ойлголт, үнэлэмж

6.3 Дотоод нөхцөл байдлыг тодорхойлох

Дотоод нөхцөл байдал бол хэлтэс нь зорилгодоо хүрэхийг эрмэлзэх үеийн дотоод орчин юм.

Авлигын эрсдэлийн менежментийн үйл явц нь хэлтсийн соёл, үйл явц, бүтэц ба стратегитай тохирсон байна. Дотоод нөхцөл байдал нь хэлтсээс эрсдэлийг удирдах арга замд нөлөөлж болох хэлтэс дэх аливаа зүйл юм. Үүнийг дараах шалтгааны улмаас тогтоох шаардлагатай байдаг. Үүнд:

- а/ менежментийг хэлтсийн зорилтын хүрээнд авч үздэг,
- б/ тодорхой төсөл, үйл явц, үйл ажиллагааны зорилт, шалгуурыг байгууллагын зорилтыг бүхэлд нь харгалзан тодорхойлно,
- в/ засаглал, бүтэц, зохион байгуулалт, үүрэг, хариуцлага,
- г/ бодлого, зорилт ба тэдгээрт хүрэх стратеги,
- д/ нөөц болон мэдлэг
- е/ дотоод оролцогч талуудын харилцаа, ойлголт, үнэлэмж,
- ё/ байгууллагын соёл,
- ж/ мэдээллийн тогтолцоо, мэдээллийн урсгал ба шийдвэр гаргах үйл явц

з/ хэлтсээс баталсан стандарт, арга зүйн заавар, баримтжуулсан мэдээлэл, чанарын гарын авлага

6.4 Авлигын эрсдэлийн шалгуурыг тодорхойлох

Шалгуур нь хэлтсийн үнэ цэнэ, зорилт болон нөөцийг илэрхийлнэ. Зарим шалгуур нь хууль, эрх зүйн зохицуулалтаар тавигдах шаардлага болон байгууллагаас тавьж буй бусад шаардлагаас урган гарч болно.

Авлигын эрсдэлийн шалгуур нь АТМТ-той нийцсэн байх бөгөөд аливаа авлигын эрсдэлийн менежментийн үйл явцын эхэнд тодорхойлогдож, байнга хянагдаж байна.

Хэлтсийн эрсдэлийн шалгуурыг тодорхойлохдоо дараах хүчин зүйлүүдийг харгалзана. Үүнд:

-тохиолдож болох үр дагавар ба шалтгааны төрөл, шинж чанар болон түүнийг хэрхэн хэмжих,

-магадлалыг хэрхэн тодорхойлох,

-магадлал болон үр дагаврын цаг хугацаа,

-эрсдэлийн түвшинг хэрхэн тодорхойлох,

-оролцогч талуудын үзэл бодол,

-эрсдэлийг хүлээн зөвшөөрөх буюу хүлцэх түвшин,

-олон төрлийн эрсдэлийн хослолыг харгалзан үзэх эсэх, хэрэв харгалзан үзсэн бол ямар хослолыг хэрхэн авч үзэх,

7. Эрсдэлийн үнэлгээ

7.1 Эрсдэлийн үнэлгээ нь дараах хэлбэрээр хийнэ.

АЭМТХАХ болон тасгийн дарга нар байгууллагын авлигын эрсдэлийн үнэлгээг хариуцан жилд 1 удаа энэхүү журмын дагуу хийнэ. Тасгийн дарга нар өөрийн тасагт хамаарах ажлын байрны тодорхойлолт заасан ажил тус бүрээр ажлын байрны авлигын эрсдэлийн үнэлгээг хариуцан жилдээ 1 удаа энэхүү журмын дагуу хийнэ.

7.2 Мэдээллийн эх үүсвэр

7.2.1 АТМТ-ны АЭМТХАХ, Тасгийн дарга нар авлигын эрсдэлийн үнэлгээг хийхдээ дараах мэдээллийн эх үүсвэрийг ашиглана.

7.2.1.1 Тоон судалгаа болон статистикийн мэдээлэл

7.2.1.2 Дотоод дүрэм, журам, стандарт, аргачлал, зөвлөмж

7.2.1.3 Аудитын тайлан

7.2.1.4 Дотоод аудит, хяналт шалгалтын ажлын тайлан, үр дүнг харуулсан бусад материал

7.2.1.5 Судалгаа, дүн шинжилгээ, тэдгээрийн тайлан, бусад материал

7.2.1.6 Өргөдөл, гомдол, мэдээлэл

7.2.1.7 Иргэний нийгмийн байгууллагуудын тайлан, мэдээлэл

7.2.1.8 Бусад мэдээлэл

7.2.2 Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтнаас ЧГА-н 3.12-д заасан эрсдэлийн шинж чанар, хэр хэмжээг тогтоох, онцгой гүйлгээ, төсөл, үйл ажиллагаа, болон хуулийн хүрээнд нээлттэй хамтран ажиллаж болох төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагуудтай холбоотой шийдвэр гаргахад ЭБАТушаалтнаас тэдгээрийг авлигаас ангид байлгахад чиглэсэн мэргэжлийн судалгаа хийж, дүгнэлт гарган туслах үүргийг хэрэгжүүлнэ.

7.3 Үнэлгээний үе шат

Үнэлгээ нь дараах үе шаттай байна:

а) Үнэлгээний баг бүрдүүлэх

Эрсдэлийн үнэлгээг гардан гүйцэтгэх багт дараах шаардлагыг хангасан хүмүүс ажиллах шаардлагатай. Үүнд:

- ✓ Тухайн салбар, байгууллагын талаар тодорхой ойлголт, мэдлэгтэй
- ✓ Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харилцааны болон бичиж боловсруулах ур чадвартай
- ✓ Судалгаа, дүн шинжилгээ, мониторинг, хяналт шалгалт, аудитын ажлын туршлагатай

б) Үнэлгээний төлөвлөгөө боловсруулах:

Төлөвлөгөөнд дараах асуудлыг хамруулна.

- ✓ Хамрах хүрээ
- ✓ Хийгдэх үйл ажиллагаа
- ✓ Хариуцах эзэн
- ✓ Хамтран оролцогч
- ✓ Хугацаа
- ✓ Гарах үр дүн

с) Эрсдэл тодорхойлох, зураглал хийх

Эрсдэлийг тодорхойлох:

- Албан хаагчдын дунд зохион байгуулсан судалгааны үр дүн (Эрсдэлийг тодорхойлох загвар асуулга жишээ хавсралт 1)
- 7.2-т заасан эх үүсвэрээс цуглуулсан мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ
- Эрсдэлийн түвшинг үнэлэх:
 - ✓ Эрсдэлийг үнэлэхдээ эрсдэлийн төрөл ба түвшингийн үзүүлэлтийг тодорхойлж, харьцуулан шинжилнэ.
 - ✓ Эрсдэлийн түвшинг үнэлэхдээ чанарын болон тоон аргаар цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийнэ.
 - ✓ Чанарын үнэлгээ нь үр дагавар, магадлалын хослолоор илэрхийлэгдэх “их”, “дунд”, “бага” гэсэн тодорхой үзүүлэлтээр эрсдэлийн түвшин, магадлал, үр дагаврыг тодорхойлж, чанарын шалгуураар эрсдэлийн түвшинг үнэлнэ.

- ✓ Тоон шинжилгээний аргаар үр дагавар ба түүний магадлалын бодит хэмжээг тооцоолох ба нөхцөл байдлыг тодорхойлох үед тогтоосон тусгай нэгжээр эрсдэлийн түвшингийн хэмжээг гаргана.
- Хэлтсээс тодорхойлсон авлигын эрсдэл бүрт тохирсон арга хэмжээг дангаар болон хослуулан авах ёстой бөгөөд эрсдэлийг хянах, удирдах үйл ажиллагаа нь энэхүү арга хэмжээний хүрээнд хийгдэнэ. Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх төвшин нь тухайн эрсдэлд ямар арга хэмжээ авахыг шийдэхэд чухал үүрэгтэй. Эрсдэлд тохирсон дараах үндсэн таван арга хэмжээнүүдийг авах боломжтой. Үүнд:
 - Эрсдэлээс зайлсхийх,
 - Эрсдэлийг бууруулах,
 - Эрсдэлийг багасгах бусад шийдлүүдийг олох
 - Эрсдэлийг хуваах, шилжүүлэх
 - Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх

Хамгийн тохиромжтой эрсдэлийн арга хэмжээний хувилбарыг сонгохдоо хууль тогтоомж, зохицуулалтын болон нийгмийн хариуцлага, хүрээлэн буй орчны хамгаалал зэрэг бусад шаардлагуудад нийцүүлэн зардал ба үр ашгийн дагуу хэрэгжилтийн ололт, амжилтын тэнцлийг авч үзнэ.

- Зураглал хийх: Эрсдэлийн зураглалд нэг төрлийн үйл ажиллагаа хамааруулж болохоос гадна олон төрлийн үйл ажиллагааг хамааруулан харьцуулж болно. Дараах үндсэн үзүүлэлтүүд байна.
(Эрсдэлийн зураглалын жишээ хавсралт 2)
 - ✓ Эрсдэлийн нөлөөлөл буюу үр дагавар
 - ✓ Эрсдэлийн магадлал буюу давтамж
 - ✓ Эрсдэлийн цар хүрээ
 - ✓ Эрсдэлийн нуугдмал байдал
 - ✓ Үргэлжилж байгаа хугацаа
 - ✓ Бусад
- Эрсдэлийн нөлөө: Харгалзан үзэх хүчин зүйлс:
 - ✓ Тухайн байгууллагад болон бусад ижил төстэй байгууллагад гарсан авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчил, ашиг сонирхлын зөрчлийн улмаас иргэдийн эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, аюулгүй байдал, амьдрах орчин, хүрээлэн байгаа орчин, байгаль орчинд үзүүлсэн нөлөө
 - ✓ Байгууллага, салбарын үйл ажиллагаанд олон нийтийн итгэх итгэлд орсон өөрчлөлт
 - ✓ Эдийн засгийн, санхүү, хөрөнгө оруулалтын алдагдал
 - ✓ Бусад
- Эрсдэлийн магадлал: Харгалзан үзэх хүчин зүйлс:
 - ✓ Тухайн хэрэг, зөрчилтэй холбогдож болох бусад үйл ажиллагаа
 - ✓ Байгууллагад өнгөрсөн хугацаанд үйлдэгдэж байсан авлигын хэрэг, зөрчлийн давтамж
 - ✓ Бусад

- Үнэлгээний хуудас: Эрсдэлийн зураглал хийхэд үнэлгээний хуудсыг ашиглана. (Үнэлгээний хуудасны загварыг хавсралт 3)
- d) Эрсдэлийг бууруулах, арилгах үйл ажиллагааг тодорхойлж төлөвлөх

Энэ үе шатанд өмнөх үе шатуудад тодорхойлогдсон эрсдэлийг баримтжуулан, бүртгэл хөтлөн, бууруулах, арилгах зөвлөмжийг боловсруулна. Зөвлөмж нь дараах шаардлагыг хангасан байна.

- ✓ Хууль тогтоомжид нийцсэн байх. Авлигыг эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны хууль болон УИХ-ын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралт “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” зэрэг хууль тогтоомжид нийцсэн байх
 - ✓ Хэрэгжих боломжтой байх
 - ✓ Тодорхой байх
- e) Үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих
- Эрсдэлийн үнэлгээний хүрээнд зөвлөмж боловсруулж хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан тушаалтанд хүргэснээс хойш хэлтсийн дарга, тухайн тасгийн дарга, АЭМТХАХ нар байгууллагын стратеги, үйл ажиллагаатай уялдуулан зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулна.
 - Уг төлөвлөгөөнд зөвлөмжийг хэрэгжүүлэх хугацаа, хариуцан хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгаж өгөх бөгөөд загварын дагуу боловсруулж болно.
 - Байгууллагын дотоод болон гадаад орчны өөрчлөлттэй холбогдуулан зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнд байгууллагын ЧУХ-ны зүгээс тогтмол хяналт тавьж, авлигын эрсдэлийг бий болгох шинэ хүчин зүйл бий болж байгаа эсэхэд жилдээ 2 удаа үнэлгээ өгнө.

8. Мониторинг ба хяналт

Мониторинг ба хяналтын аль аль нь эрсдэлийн менежментийн үйл явцын төлөвлөгдсөн хэсэг байх бөгөөд тогтмол шалгалт эсвэл ажиглалтыг агуулна. Дараах зорилгын үүднээс эрсдэлийн менежментийн үйл явцын бүх асуудалд хамаарна. Үүнд:

- Хяналтын загвар ба ажиллагааны аль алинд нь үр нөлөөтэй, үр дүнтэй байлгах,
- Эрсдэлийн үнэлгээг сайжруулахад шаардлагатай мэдээлэл олж авах,
- Тохиолдол, өөрчлөлт, чиг хандлага, амжилт болон алдаагаа шинжлэх, сургамж авах,
- Эрсдэлийн шалгуурыг өөрчлөгдөхөд хүргэх дотоод, гадаад нөхцөл байдлын өөрчлөлт болон эрсдэлийн арга хэмжээг нэмж засварлах шаардлага, нэн тэргүүний асуудлыг илрүүлэх,
- Шинээр үүсэж буй эрсдэлийг олж тогтоох.